

**ЖУРМЫН ТӨСЛИЙН ХАВСРАЛТ 3
ОЛОН НИЙТЭД ХЭЛЭЛЦҮҮЛЭХ**

**ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ
ҮНЭЛЭХ АСУУЛГА**

МОНГОЛБАНК

Асуулгын зорилго

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 19.1-д зааснаар Монголбанк нь банкинд МУТС-тэй тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих эрх, үүрэгтэй.

Энэхүү асуулгын зорилго нь банк өөрийн мөнгө угаах, терроризмыг болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны эрсдэлийг тооцох, үнэлэх, хянах бууруулах арга хэмжээ авах тогтолцооны үр дүнтэй, оновчтой байдлыг үнэлэхэд оршино.

Энэхүү асуулга нь банкны МУТС болон үй олноор нөхөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны эрсдэлийн нэгдсэн үнэлгээг хийхэд Тоон өгөгдөл цуглуулах маягтаар авсан бизнесийн үйл ажиллагааны тоон мэдээлэлтэй нэгтгэгдэн үнэлдэгдэх болно.

Банкны МУТС-тэй тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилтэд Монголбанк эрсдэлд суурилсан хэлбэрээр хяналт шалгалт хийх тул өөрийн банкны эрсдэлийг зөв үнэлүүлэх үүднээс асуулгын бүрэн гүйцэт, тодорхой хариулахад анхаарна уу. Мэдээллийн үнэн бодит байдалд улирлын тайлан болон, батлагдсан бодлого, журмын бүртгэл, өмнө хийсэн шалгалтын материал, СМА-наас авсан мэдээлэл дээр үндэслэн хяналт тавих болно. Газар дээрх шалгалтын үеэр зайнаас авсан мэдээллийн үнэт бодит байдлыг нягтлах болно.

Түүнчлэн банк энэхүү асуулгад хариулах явцдаа өөрийн хяналтын тогтолцоог эргэж харах шаардлагатай зарим сайжруулалтыг хийх сэдлийг төрүүлэх ач холбогдолтой байж болох юм.

Банкны Нэр:

Чиглэл 1: МУТС-тэй тэмцэх банкны бүтэц зохион байгуулалт, ТУЗ болон түүний дэргэдэх хороодын оролцоо/Зохистой засаглал/	Хууль, журам, зааврын холбогдох зүйл заалт ¹	Тийм/Үгүй	Тайлбар	Хянан шалгагчийн өгсөн тайлбар	Үнэлгээ
Ерөнхий бодлого журам					
1. Банкны ТУЗ Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод бодлого журмыг баталдаг эсэх					
2. МУТС-тэй тэмцэх дотоод бодлого журмыг шинэчлэх шаардлагатай эсэхийг хэрхэн, ямар хугацааны давтамжтай шалгадаг вэ?					
3. ТУЗ мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод бодлого журмын олон улсын стандарт болон дотоодын хууль эрх зүйн орчинд нийцтэй байдалд анхаардаг уу? Хөтөлбөрийн онцлог болон МУТС-тэй тэмцэх хууль журамд хэрхэн нийцэж байгаа талаар тайлбарлана уу?					
4. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод бодлого журмыг дотооддоо хэрхэн таниулж, бүх шатны ажилтан, нэгжүүд үр дүнтэй хэрэгжүүлж байгаа эсэхэд ТУЗ хэрхэн хяналт тавьдаг вэ?					
5. Мөнгө угаах болон терроризмын санхүүжилттэй тэмцэх дотоод бодлого журмын хэрэгжилтэнд ТУЗ хэрхэн хяналт шалгадаг вэ? МУТС эрсдлийн удирдлага, Сэжигтэй болон бэлэн мөнгөн гүйлгээг мэдээлэх шалгуурын хангаж байгаа эсэхэд яаж хяналт шалгалт хийдэг вэ?					
6. ТУЗ-ийн гишүүдээс хэн нэгэн МУТС-тэй тэмцэх асуудлыг хариуцаж					

¹Хууль, журам, заавар

ажилладаг уу?, эсвэл МУТС-тэй тэмцэх алба, хороо байгуулсан уу?					
7. МУТС-тэй тэмцэх хүлээсэн үүргээ биелүүлэх дотоод хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотой ямар төрлийн тайлан мэдээг ТУЗ хүлээж авдаг вэ? Хэн, ямар хугацааны давтамжтайгаар тайлан мэдээг ТУЗ-д өгдөг вэ? Эдгээр тайлан мэдээнд МУ болон ТС эрсдэл, Сэжигтэй гүйлгээг мэдээлэх гэх мэт зүйлсийг тусгадаг уу?					
8. ТУЗ хүлээн авсан тайландаа үндэслэн гүйцэтгэх удирдлагад санал зөвлөмжөө өгөх ямар арга хэмжээ авдаг вэ?					
9. МУТС-тэй тэмцэх чиглэлээр нэг талд ТУЗ ба нөгөө талд Дотоод аудит, хэрэгжилт хариуцсан нэгжтэй мэдээлэл солилцох ба харилцахдаа ямар уялдаа холбоотой ажилладаг талаар тайлбарлана уу?					
10. ТУЗ эсвэл МУТС-тэй тэмцэх хорооны гишүүдээс хэрэгжилт хариуцсан ажилтантай тодорхой цаг хугацааны давтамжтайгаар уулзалт хийдэг үү? Хийдэг бол ямар хугацааны давтамжтай уулздаг вэ?					
11. ТУЗ-аас МУТС эрсдэлтэй холбогдуулан тусгайлан эрсдлийн удирдлагын бодлого, журам гаргасан уу?					
12. ТУЗ ёсзүй, комплаенсийн журам, дүрэм боловсруулж, ажилтнуудад танилцуулсан эсэх; энэ дүрэмд МУТС-тэй тэмцэх асуудлаар холбоотой зүйл заалтууд орсон эсэх;					
Удирдлагын мэдээллийн систем					
13. Танай банк харилцагчийн гүйлгээний мэдээллээс онцгой, сэжигтэй гүйлгээг илрүүлж, дүн шинжилгээ хийж, хяналт тавьж, тайлан гаргаж чадах мэдээллийн системтэй юу?					
14. Танай банк харилцагчийн мэдээллээр мэдээллийн сан үүсгэдэг үү? Хэрэв тийм					

бол дээр дурьдсан мэдээллийн системтэй мэдээллийн санг уялдуулж нэгтгэсэн үү?					
15. Мэдээллийн систем сэжигтэй байж болох гүйлгээг тодорхой шалгуураар ялгаж гаргах чадвартай эсэх; Хэрэв тийм бол (ялгаж гаргасан) үр дүнгийн статистикийг гаргаж өгнө үү.					
16. Гүйцэтгэх удирдлага болон ТУЗ мэдээллийн системийн МУТС-тэй холбоотой тайлан, дүгнэлтийг хүлээн авч хардаг эсэх;					
Дундаж үнэлгээ					
Тэмдэглэл					
Чиглэл 2: Дотоод бодлого, журам: Харилцагчийг таньж мэдэх (CDD/KYC)	Хууль, журам, зааврын холбогдох зүйл заалт	Тийм/ Үгүй	Тайлбар	Хянан шалгагчийн тайлбар	Үнэлгээ
1. Танай банк харилцагчийг таньж мэдэх зарчмыг хэрэгжүүлэх баримтжуулсан бодлого журамтай юу?					
3. Харилцагчийг таньж мэдэх бодлого, журмыг ямар хугацааны давтамжтайгаар шалгаж, шинэчилдэг вэ? Хамгийн сүүлд хэзээ шинэчилсэн бэ?					
2. МУТС-тэй тэмцэх бодлого журмыг банкны бүх салбар нэгж, ажилтнууд, удирдлагуудад танилцуулж, нэвтрүүлсэн үү? Яаж танилцуулж, нэвтрүүлсэн бэ?					
4. Танай банк дараах төрлийн харилцагчдыг тодорхойлж, баримтжуулах МУТС-ээс сэргийлэх харилцагчийг таньж мэдэх бодлого журам хэрэгжүүлдэг үү? <ul style="list-style-type: none"> • Байнгын оршин суугч хувь хүн • Түр оршин суугч хувь хүн • Хуулийн этгээд: компани гэх мэт • Эцсийн өмчлөгч • корреспондент банкны харилцаа 					

<ul style="list-style-type: none"> • Улс төрд нөлөөтэй этгээд • Ашгийн бус байгууллага • Үл хөдлөх хөрөнгө зуучлалын байгууллага • Үнэт чулуу, эдлэлийн арилжаа эрхлэгч • Үйлчүүлэгчээ төлөөлөн санхүүгийн харилцаа үүсгэж буй нягтлан бодогч, хуульч 					
5. Дээрх бодлого журам орон нутгийн бүх салбар нэгж, группын хэмжээнд хэрэгжиж байгаа юу?					
6. МУТС-тэй тэмцэх бодлого журам гадаад дахь бүх салбар, охин компаниудад хэрэгжиж юу?					
7. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, журам, мөн харилцагчийг таньж мэдэх бодлого журмын хэрэгжилтийг туршиж шалгах системтэй юу?					
8. Харилцагчийг таньж мэдэх бодлого журам дараах зүйлсийг хамарч байгаа эсэх; Үүнд: <ul style="list-style-type: none"> • Харилцагчийг хүлээн авах, харилцагчаас татгалзах; • Өндөр эрсдэл бүхий харилцагч, бүтээгдэхүүн үйлчилгээ, гүйлгээ гэх мэт үйл ажиллагаанд авч хэрэгжүүлэх нарийвчилсан харилцагчийг таньж мэдэх ажиллагаа • Хялбаршуулсан байдлаар харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа • Харилцагчийн данс болон гүйлгээнд тавих хяналтын үйл ажиллагаа; • Сэжигтэй гүйлгээг дотооддоо болон гадны байгууллагад (СМА) дамжуулах, мэдээлэх; 	➤				
9. Танай МУТС-тэй тэмцэх Харилцагчийг таньж мэдэх бодлого журам дараах зүйлсийг хийхийг шаарддаг эсэх; Үүнд:	➤				

<p>a) Бизнесийн харилцаа/гүйлгээний зориулалт болон зорилтыг тодорхойлж тэмдэглэдэг эсэх;</p> <p>b) Улс төрд нөлөөтэй этгээд ба бусад өндөр эрсдэлтэй харилцагч, гүйлгээнд тавих тодорхой харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа байгаа эсэх;</p> <p>c) Танай банкинд хилийн чанд дахь банкны харилцаа, УТНБЭ-тэй харилцах харилцаа, өндөр эрсдэлтэй харилцагч, гүйлгээг хянан зохицуулах эрх бүхий ажилтныг томилсон уу?</p> <p>d) Харилцагчийн хувийн хэргийн мэдээллийг шинэчилдэг эсэх;</p> <p>e) Харилцагчийг таньж мэдэх болон гүйлгээний мэдээллийг хадгалдаг уу? Мэдээллийг ямар хугацаанд хадгалдаг вэ?</p> <p>f) Эцсийн өмчлөлийг тогтоох талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ, шат дарааллыг тоочно уу.</p>					
<p>10. Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хийх боломжгүй эсхүл шаардлагатай мэдээллийг өгөхөөс татгалзсан тохиолдолд ямар арга хэмжээ авдаг вэ?</p>					
<p>11. Хэрэв харилцагч хэн нэгэн этгээдийг төлөөлөн танай банктай санхүүгийн харилцаа үүсгэж байгаа бол эцсийн өмчлөгчийг тогтоох зорилгоор доорх болон өөр бусад мэдээллийг авдаг уу? Үүнд:</p> <p>a) Харилцаа үүсгэх журамд заасан хувь хүнээс авах бүх мэдээлэл.</p> <p>b) Ямар гэрээ хэлцэл, эрс зүйн баримт бичиг дээр үндэслэн эцсийн өмчлөг гэж тогтоосон талаарх баримт,</p> <p>c) Эцсийн өмчлөгчийн эд хөрөнгийн гарал үүслийн талаарх мэдээлэл</p> <p>d) Компанийн гүйцэтгэх удирдлага, төлөөлж байгаа этгээдийн, паспорт, бичиг баримт.</p>					

<p>12. Харилцагчийг таньж мэдэх, баталгаажуулах үйл ажиллагаа нь дараах зүйлсийг агуулсан уу? Үүнд:</p> <p>a) Бичиг баримтын үнэн зөв эсэхийг шалгах.</p> <p>b) харилцагчтай биечлэн уулзах уулзалт хийх; ямар үед биечлэн уулзах шаардлагагүй байдаг вэ?</p> <p>c) Харилцагчийн өгсөн мэдээллийг өөр бусад этгээдийн мэдээлэлтэй тулган шалгах.</p> <p>d) Өндөр эрсдэлтэй эсвэл өндөр эрсдэлтэй бизнес үйлчилгээтэй холбоотой, өндөр эрсдэлтэй улс орны харилцагчдад бичиг баримтыг баталгаажуулах үйл ажиллагааг тодорхой журам, зааврын дагуу хийж гүйцэтгэх.</p> <p>e) Ийм төрлийн компаниудаас бизнес, байршил, санхүүгийн тайлан, урьдчилсан төлөвлөгөөт гүйлгээ зэргийн талаарх мэдээлэл нэмж авах..</p>					
<p>13. Танай банкны харилцагчийг таньж мэдэх бодлого журамд харилцагчийг өндөр эрсдэлтэй гэж тодорхойлсон албан ёсны жагсаалт эсвэл олон улсын байгууллага, ФАТФ-ын хар жагсаалт, НҮБ-ын АЗ-ийн хориг, террорист этгээдийн жагсаалттай тулган шалгадаг уу?</p>					
<p>14. Танай банк ямар төрлийн харилцагчидтай бизнесийн харилцаа үүсгэхээс татгалздаг вэ? Яагаад гэдгийг бичнэ үү.</p>					
<p>15. Эд хөрөнгийг шилжүүлж байгаа үед, Танай банк шилжүүлэгч бүрийн дараах мэдээллийг авч хадгалдаг уу? (Энэхүү мэдээллийг төлбөрийн даалгаварт оруулан, мөн тухайн харилцагч банкнаас зээл авсан эсвэл хадгаламж эзэмшиг бол банкны хувийн хэрэгт мэдээллийг оруулан авч болно):</p>					

<ul style="list-style-type: none"> a) Шилжүүлэгчийн нэр хаяг; b) Шилжүүлж буй эд хөрөнгийн хэмжээ; c) Шилжүүлгийн огноо; d) Өөр бусад төлбөрийн зааварчилгаа; e) Хүлээн авагч банкны мэдээлэл; f) Хүлээн авч буй этгээдийн нэр хаяг, дансны дугаар. 					
Харилцагчийг таньж мэдэх: Гуравдагч этгээдээр ХТМ үйл ажиллагааг хийлгэх					
<p>16. ХТМ үйл ажиллагааг гуравдагч этгээдээр хийлгэх эсхүл гуравдагч этгээдийн гаргаж өгсөн мэдээллийг шууд авч ашиглахтай холбоотой ямар зохицуулалт байдаг бэ? :</p> <ul style="list-style-type: none"> a) Ийм тохиолдолд ХТМ-тэй холбоотой хуулиар хүлээсэн үүрэг хариуцлагаас чөлөөлөгдөхгүй гэдгийг холбогдох бодлого, журамд тусгасан эсэх b) Гуравдагч этгээдийн гаргаж өгсөн мэдээллийг хэрхэн нягталж баталгаажуулдаг талаар бичнэ үү. 					
Дундаж үнэлгээ					
Тэмдэглэл					
Чиглэл 3: Эрсдэлийн удирдлага	Хууль, журам, зааврын холбогдох зүйл заалт	Тийм/ Үгүй	Тайлбар	Хянан шалгагчын тайлбар	Үнэлгээ
1. Танай банкинд мэргэжлийн эрсдэлийн удирдлагын баг эсвэл банкин дотроо эрсдэлийн алба ажилладаг уу? Хэрэв ажилладаг бол үйл ажиллагаандаа мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг тусгадаг уу?					
2. Танай банк мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн					

<p>үнэлгээнд шинэчлэл хийдэг үү? Хэрэв хийдэг бол ийм үнэлгээний цар хүрээ, хэдийд, ямар тохиолдолд эсхүл давтамжийн талаар тайлбарлаж бичнэ үү.</p> <ul style="list-style-type: none"> • Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, бодлого журам, харилцагчид, газарзүйн байршил, хүргэлтийн суваг, болон гуравдагч этгээдээр дамжин хийгддэг үйл ажиллагаанаас учирч болох эрсдэлүүдийг тооцох талаар бодлого, журамд тусгасан эсэх 					
<p>3. Танай банк Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг ангилж ялгадаг системтэй юу? Хэрэв байгаа бол тайлбарлана уу?</p>					
<p>4. Тодорхой төрөл эсвэл ангиллаар өндөр эрсдэлтэй гэж ялгасан бүтээгдэхүүн үйлчилгээ, харилцагчид байгаа юу? Ямар ангиллаар ялгаж, хэдийг нь эрсдэлтэй гэж тодорхойлсон бэ?</p>					
<p>5. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлтэй бизнес хийж байгаа гэсэн үндэслэлээр банк харилцахаас татгалзсан харилцагчид байгаа юу?</p>					
<p>6. ТУЗ банкны бизнесийг өргөжүүлэхдээ МУ болон ТС эрсдлийг анхаарч үздэг үү? <i>(Жишээлбэл дотооддоо болон гадаадад шинэ салбар, нэгж нээх, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ гаргах, шинэ хүргэлтийн суваг нэвтрүүлэх зэрэг)</i>Танай банк бизнес эрхэлж буй газруудаас өндөр эрсдэлтэй гэж тодорхойлогдсон газар байгаа юу?</p>	-				
<p>7. Шинээр бүтээгдэхүүн үйлчилгээ, бодлого журам гаргахдаа МУТС эрсдэлийг нь үнэлэх үйл ажиллагаа авч хэрэгжүүлдэг үү? Хэрэв тийм бол ийм эрсдэлийн үнэлгээнд хэн оролцдог вэ?</p>					
<p>8. ТУЗ болон Дээд удирдлагад МУ болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн түвшингийн өөрчлөлтийг мэдэгддэг үү?</p>					

Хэрэв тийм бол яаж мэдээлж, танилцуулдаг вэ?					
Дундаж үнэлгээ					
Тэмдэглэл					
Чиглэл 4:Дотоод хяналт ба Дотоод болон хөндлөнгийн аудит	Хууль, журам, зааврын холбогдох зүйл заалт	Тийм/ Үгүй	Тайлбар	Хянан шалгагчын тайлбар	Үнэлгээ
1. Танай банк дотоод аудитын нэгжтэй юу? Дотоод аудитын нэгж МУТС-тэй тэмцэх тогтолцоо, Харилцагчийг таньж мэдэх бодлого журам зэрэгт төлөвлөгөөний дагуу шалгалт хийж, уг хөтөлбөрийг хянадаг уу?					
2. Хэрэв 1-д тийм гэж хариулсан бол шалгалтыг ямар давтамжтай хийдэг вэ? Хамгийн сүүлд дотоод аудит хэзээ шалгалт хийсэн бэ? Шалгалтын цар хүрээ болон олж авсан мэдээллийн талаар тайлбарлана уу?					
3. Дотоод аудитийн үйл ажиллагааг баримтжуулдаг уу? Хэрэв тийм бол хувийг 1 хувийг өгнө үү.					
4. Аудитын газрын цар хүрээ, орон тооны хэд вэ? Ямар хугацааг МУТС-тэй тэмцэх чиглэлийн шалгалтанд зарцуулдаг вэ?					
5. Дотоод аудитын үйл ажиллагаа эрсдэлд суурилсан МУТС-тэй тэмцэх тогтолцоотой уялддаг эсэх; Улс төрд нөлөөтэй этгээд болон бусад өндөр эрсдэлтэй харилцагчилтай харилцах бодлого журам хууль журамд нийцэж байгаа эсэхийг шалгадаг уу?					

6. Сүүлчийн аудитын шалгалтаар сэжигтэй гүйлгээг ба үйл ажиллагааг илрүүлэх, мэдээлэх системийг шалгасан уу?					
7. Дотоод аудитын дүгнэлтийг хянаж үздэг системийг тайлбарлана уу? Хэн дотоод аудитын тайланг хүлээн авдаг вэ? Дотоод аудитын тайланд МУТС-тэй тэмцэх чиглэлийн асуудал ордог уу? Хэрэв ордог бол тайлбарлаж бичнэ үү.					
8. Аудитын тайланг захирлуудын зөвлөлөөс бүрдсэн хороо хүлээж авдаг уу? МУТС-тэй тэмцэх чиглэлийн аудитын тайланг ТУЗ хянаж үздэг үү?					
9. Дотоод аудит комплаенс буюу хэргжилтийн үйл ажилладаг шалгадаг уу? Хамгийн сүүлд хэзээ шалгасан бэ? Ямар зөрчил дутагдал илрүүлсэн бэ?					
10. Хөндлөнгийн аудитын хяналт шалгалт МУТС-тэй тэмцэх дотоод хяналтын орчинг хамарч хяналт шалгалт хийдэг үү? Хэрэв тийм бол ямар зөрчил дутагдал илрүүлсэн бэ? Тэдгээрийг удирдлагад хэрхэн танилцуулдаг вэ?					
Дундаж үнэлгээ					
Тэмдэглэл					
Чиглэл 5: Комплаинс буюу хэрэгжилт	Хууль, журам, зааврын холбогдох зүйл заалт	Тийм/ Үгүй	Тайлбар	Хянан шалгагчын тайлбар	Үнэлгээ
1. Танай банк МУТС-тэй тэмцэх хэрэгжилт хариуцсан ажилтныг томилсон уу? Хэрэв тийм бол нэр, байгууллага дахь албан тушаал, үүрэг					

хариуцлага зэргийг бичнэ үү. Хэрэгжилт хариуцсан ажилтан удирдлагын түвшинд ажилладаг уу?					
2. МУТС-тэй тэмцэх хэрэгжилт хариуцсан ажилтны мэргэжлийн чадвар, суусан сургалт, үүрэг хариуцлагын талаарх мэдээллийг ирүүлнэ үү. /тусад нь дэлгэрэнгүй мэдээлэл хавсаргаж болно/					
3. Танай банкны салбар нэгж бүр хэрэгжилт хариуцсан ажилтантай юу? Хэрэв тийм бол толгой салбар дахь хэрэгжилт хариуцсан ажилтантай хэрхэн харилцдаг талаар тайлбарлана уу.					
4. Группын хэмжээнд хэрэгжилтийн тогтолцоотой юу? Хэрэв тийм бол хэрэгжилт хариуцсан нэгжүүдтэй ямар холбоотой ажилладаг талаар тайлбарлана уу?					
5. Танай хэрэгжилт хариуцсан ажилтан МУТС-тэй тэмцэх чиглэлээс өөр бусад үүрэг хариуцлага хүлээдэг үү? Хэрэв тийм бол өөр ямар ажил хийдэг вэ? МУТС-тэй тэмцэх чиглэлээр ямар хугацаа зориулж ажилладаг вэ?					
6. Хэрэгжилт хариуцсан ажилтан тайлангаа хэнд өгдөг вэ? Ажлаа хэнд тайлагнадаг вэ?					
7. Хэрэгжилт хариуцсан ажилтны сүүлийн 2 улирлын хийсэн ажлын тайланг хавсарган уу.					
8. Хэрэгжилт хариуцсан ажилтны ажил , үүргийг тайлбарлаж бичнэ үү. (a) Сэжигтэй үйл ажиллагаанд тавих хяналт ба сэжигтэй гүйлгээг мэдээлэх; (b) сургалт; (c) эрсдэлийн систем болон хяналтын тогтолцоог хөгжүүлэх; (d) бусад газар, нэгжтэй хамтын ажиллагаа					
Дундаж үнэлгээ					
Тэмдэглэл					

Чиглэл 6: Сургалт, Хүний нөөц	Хууль, журам, зааврын холбогдох зүйл заалт	Тийм/Үгүй	Тайлбар	Хянан шалгагчийн үнэлгээ	Үнэлгээ
1. МУТС-тэй тэмцэх чиглэлээр ажилчдад зориулсан сургалтын хөтөлбөртэй эсэх;					
2. Хэрэгжилт хариуцсан ажилтан Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх арга хэрэгсэл, типологи, Харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй үйл ажиллагаанд хяналт тавих, мэдээллийг хадгалахгэх зэрэг мэргэжлийн чиглэлээр сургалтанд хамрагддаг эсэх;					
3. МУТС-тэй тэмцэх чиглэлээр ямар төрлийн ² сургалтыг ажилтнууддаа хийдэг вэ? Хамгийн сүүлд хэзээ хийсэн вэ?					
4. Сургалтыг ямар давтамжтайгаар хийдэг вэ?					
5. Шинэ болон хуучин ажилтнуудад зориулсан өөр өөр төрлийн МУТС-тэй тэмцэх чиглэлээр сургалтын хөтөлбөртэй эсэх; Жишээлбэл үйл ажиллагааны төрөл, албан тушаал зэрэгт тохирох гэх мэт					
6. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага МУТС-тэй тэмцэх чиглэлээр хийгдэж буй сургалтанд хамрагддаг эсэх; Хэрэв тийм бол оролцоог тодорхойлно уу?					
7. Танай банк хийсэн сургалтын ирц, хэрэглэсэн материал зэргийг баримтжуулж хадгалдаг уу?					
8. Танай банк МУТС-тэй тэмцэх хууль, журамд орсон өөрчлөлтийг тухай бүрт нь дотоод бодлого журамдаа оруулж, ажилчдынхаа үйл ажиллагаанд нэвтрүүлдэг үү?					
9. Өмнөх жил болон энэ жилийн МУТС-тэй тэмцэх чиглэлээр хийх сургалтанд зориулж төсөвлөсөн төсвийн хэмжээг бичнэ үү.					

²Төрөл нь сургалт, семинар, байгууллага дотроо, компьютерт суурилсан гэх мэт бусад хэлбэрүүд

10. Танай банк шинээр орж буй ажилтнуудаа тодорхой шалгуураар шалгадаг уу? (Үүнд: цагдаагийн тодорхойлолт, ажлын турлилага, гэх мэт) Хэрэв тийм бол, Ямар ямар шалгуураар шалгаж авдаг вэ?					
Дундаж үнэлгээ					
Тэмдэглэл					
Чиглэл 7: Мэдээлэх үүрэг ба Түүний хадгалалт	Хууль, журам, зааврын холбогдох зүйл заалт	Тийм/ Үгүй	Тайлбар	Хянан шалгагчын тайлбар	Үнэлгээ
Хяналт шинжилгээ ба сэжигтэй үйл ажиллагааг мэдээлэх					
1. Танай банк сэжиг бүхий үйл ажиллагааг илрүүлж, мэдээлдэг дотоод систем, тогтолцоотой юу? Хэрэв тийм бол, гар ажиллагаатай эсвэл автомат системтэй эсэх;					
2. Үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх болон терроризмын санхүүжилтэнд хяналт хийх тусгай системтэй юу? Хэрэв тийм бол нарийн тайлбарлана уу. Гүйлгээг нэн даруй царцаах, мэдээлэх боломж бүрдсэн эсэх /НҮБ-ын хориг, НҮБ-ын АЗ-ийн тогтоол, ФАТФ-ын хар жагсаалтыг хамруулна/					
3. Сэжигтэй үйл ажиллагааг илрүүлж, мэдээлдэг систем танай банкны бүх салбар нэгж, охин компани гээд группын хэмжээнд ажилладаг уу? Гадаадын охин компани салбаруудад ямар байдлаар ажилладаг вэ?					

4. 3-т тийм гэж хариулсан бол энэхүү механизмыг бүтцийн схемийг хавсаргана уу.					
5. Хэрэгжилт хариуцсан ажилтан нэгж нь салбараас ирүүлсэн тайланд анализ дүн шинжилгээ хийдэг үү?					
6. Онцгой болон сэжигтэй үйл ажиллагааны талаарх мэдээллийг зөвшөөрөгдөөгүй гуравдагч этгээдэд санаатай болон санамсаргүйгээр задруулахаас сэргийлэх зорилгоор хэрэглэж байгаа аюулгүй ажиллагаа байдаг бол түүний талаар тайлбарлна уу.					
7. Хяналтын болон сэжигтэй гүйлгээг мэдээлэх механизм бүх харилцагчдад адилхан уу? Улс төрд нөлөөтэй этгээдийн хувьд ямар арга хэмжээ авч хэрэгжүүлдэг вэ?					
8. Ашгийн бус байгууллагын дансны сэжигтэй үйл ажиллагаа болон гүйлгээнд терроризмыг санхүүжүүлэх зэрэг буруугаар ашиглахаас сэргийлэх зорилгоор нэмэлт хяналт тавьдаг уу? Өөр бусад харилцагчийн ангилал байдаг уу?					
9. Танай банк данс, гүйлгээ болон үйл ажиллагаанд онцгой сэжигтэй зүйл илрүүлсэн бол ямар арга хэмжээ авч хэрэгжүүлдэг вэ? Эдгээр авч хэрэгжүүлдэг арга хэмжээг бичиг баримтаар баталгаажуулж, ажилтнуудад танилцуулсан эсэх;					
10. СМА-нд сэжигтэй гүйлгээний тайлангаар мэдээлэх эсэхийг шийдэхдээ хийдэг дүн шинжилгээний аргачлалыг тайлбарлана уу?					
11. Онцгой болон сэжигтэй гэж илрүүлсэн үйл ажиллагаанд хэн анализ, дүн шинжилгээ хийдэг вэ?					

12. Сэжигтэй гүйлгээний тайлангаар мэдээлэх эсэх шийдвэрийг хэн гаргадаг вэ?					
13. Өнгөрсөн 3 жилийн хугацаанд СМА-нд хэдэн сэжигтэй гүйлгээний тайлан явуулсан вэ? Жил жилээр нь ангилж гаргана уу.					
14. Аливаа зорилгогүйгээр сэжигтэй гүйлгээний тайлан явуулсан тохиолдолд ажилдаа хамгаалах бодлого журамтай юу?					
15. Данс гүйлгээнд хяналт тавих, мэдээлэх бодлого журмыг зөрчсөн ажилтанд захиргааны арга хэмжээ авдаг уу? Өнгөрсөн 3 жилийн хугацаанд ийм зорилгоор авсан арга хэмжээ байгаа юу?					
16. Танай банкинд олон удаагийн гүйлгээгээр бэлэн мөнгө дансанд байршуулаад Монгол улс дотроо эсвэл гадагшаагаа цахим гүйлгээгээр шилжсэн тохиолдлыг хянах үйл ажиллагаа байгаа эсэх;					
Бичиг баримтын хадгалалт					
17. Мэдээллийг хадгалах бодлого журамтай эсэх; Хэрэв байгаа бол ямар бодлого журам хэрэгжүүлдэг вэ?					
18. Бичиг баримтын хадгалалтыг яаж хийдэг вэ? Цаасаар, Rareg, цахим, электрон хэлбэрээр, тухайн газар дээр нь, өөр газар хадгалдаг эсэх					
19. Мэдээллийн хадгалалт гүйлгээг хөөж шалгах боломжийг бүрдүүлж байгаа эсэх, дансны баримт бүрэн бүтэн эсэх; Энэхүү системийг туршсан эсэх; Хэрэв туршсан бол хэн хэзээ туршсан талаар бичих;					
20. Мэдээллийг хадгалахтай холбоотой ямар аюулгүй ажиллагааны арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа вэ?					
21. Мэдээлэлд хандах, гаргаж өгөх процессыг тодорхойлно уу. Тодорхой					

харилцагчийн талаарх 5 хүртэлх жилийн өмнөх мэдээллийг гаргаж өгөхөд хэр хугацаа шаардлагатай вэ? Энэ системийг туршиж үзсэн үү?					
22. Харилцагчийн мэдээллийг авах тухай хүсэлт эрх бүхий байгууллагаас ирсэн үү? (Жишээлбэл СМА-аас)Ямар үр дүнд хүрсэн бэ?					
Дундаж үнэлгээ					
Тэмдэглэл					

ОГНОО:.....
ҮНЭЛГЭЭ:
ХЯНАН ШАЛГАГЧИЙН НЭР:
ГАРЫН ҮСЭГ: